Г.Батзориг нь Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Гегатера тех” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байхдаа 2019 оны 11 дүгээр сарын тайлант хугацаанд “Э” ХХК-аас 32 ширхэг падаанаар 911,668,863.64 төгрөгийн, 2019 оны 12 дугаар сарын тайлант хугацаанд “И” ХХК-аас 6 ширхэг падаанаар 186,363,636.36 төгрөгийн бараа үйлчилгээг худалдан авсан мэтээр зориуд худал тодорхойлон, хий бичилтийг бусдаар хийлгэн худалдан авалтын буцаалт хэсэгт тусгаж, төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татварын дүнг нийт 109,803,250 төгрөгөөр бууруулан татвар төлөхөөс зайлсхийсэн буюу Эрүүгийн хуулийн 18.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдсон.